

ХДХВ, тэмбүүгийн халдвартыг илрүүлэх ийлдэс судлалын тандалт судалгаа (ИСС), БЗДХ-ыг илрүүлэх молекул биологийн судалгаа (МБС), Зан үйлийн тандалт судалгааг (ЗҮС) хийв. ИСС болон МБС-нд судалгаанд хамрагдсан хүн амаас цус, үтреэ болон умайн хүзүүний сувгаас сорыц цуглуулж ХДХВ, тэмбүү, заг хүйтэн, хламид, трихомониазийн халдварт илрүүлэх шинжилгээ хийв. ЗҮС-нд тусгайлан боловсруулсан асуумж, ярилцлагаар хэлбэрээр мэдээллийг цуглуулав.

ХДХВ, тэмбүүгийн халдварт илрүүлэх ийлдэс судлалын шинжилгээнд эмэгтэй биеэ үнэлэгч (ЭБҮ) 858, эрэгтэйтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэй (ЭБЭ) 167, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгч 2141, хөдөлгөөнтэй эрэгтэй 829, жирэмсэн эмэгтэй 409, цусны донор 400, сүрьеэтэй 143 өвчтөнийг хамруулав.

**Үр дүн:** ХДХВ-ийн халдварт ЭБҮ, хөдөлгөөнтэй эрэгтэйчүүд, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчид, жирэмсэн эмэгтэйчүүд, цусны донор, сүрьеэтэй өвчтөнүүдийн дунд 0%, ЭБЭ-ийн дунд 1.8%-тай илэрсэн. Тэмбүүгийн халдварт ЭБҮ-ийн дунд 18.3%, хөдөлгөөнтэй эрэгтэйчүүдийн дунд 1.7%, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчидийн дунд 6.9%, ЭБЭ-ийн дунд 5.4%, жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд 1.7%, цусны доноруудын дунд 1.5%-тай байв. Заг хүйтэн, трихомониаз, хламидийн халдварт илрүүлэх полимеразын гинжин урвалын шинжилгээнд 257 ЭБҮ-ийг хамруулснаас хламидын халдвартын тархалт 25.5%, трихомониазын халдварт 14.8%, заг хүйтний халдварт 15.6%-тай байна.

Зан үйлийн тандалт судалгааг ЭБҮ 722, ЭБЭ 209, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчид 2172, хөдөлгөөнтэй эрэгтэйчүүд 939 болон 15-24 насын гэр бүлгүй 2068 залуучуудын дунд явуулав.

ХДХВ-ийн халдварт, бэлгийн замаар дамжихаас сэргийлэх аргуудыг зөв тодорхойлж үндсэн ташаа ойлголтуудыг үгүйсгэсэн хүмүүсийн эзлэх хувь ЭБҮ-ийн дунд 50.4%, ЭБЭ-ийн дунд 56.3%, хөдөлгөөнтэй эрэгтэйчүүдийн дунд 24%, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчидийн дунд 29.6%, 15-24 насын залуучуудын дунд 20.3%-тай байсан.

ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан хувь ЭБҮ-ийн дунд 74%, ЭБЭ-ийн дунд 78.6%, хөдөлгөөнтэй эрэгтэйчүүдийн дунд 27%, БЗДХ-ын кабинетийн эрэгтэй үйлчлүүлэгчидийн дунд 31.5%, 15-24 насын залуучуудын дунд 11.7%-тай байв.

#### Дүгнэлт:

1. ЭБЭ-ийн дунд ХДХВ-ийн халдвартын тархалт 1.8%-тай байгаа нь өмнөх онуудын ХТС-тай харьцуулахад ХДХВ-ийн халдвартын тархалт нэмэгдэх хандлагатай байна.

2. ЭБҮ-ийн дунд тэмбүүгийн халдвартын тархалт

бусад судалгаанд хамрагдсан бүлэгтэй харьцуулахад хамгийн өндөр, өмнөх онуудтай харьцуулахад түүштэй буурахгүй байна.

3. 15-24 насын залуучуудын ХДХВ-ийн халдвараас урьдчилан сэргийлэх хөтөлбөрт хамрагдсан байдал болон ХДХВ/ДОХ-ын талаар цогц, зөв мэдлэгийн түвшин өмнөх онуудтай харьцуулахад буурсан, судалгаанд хамрагдсан бусад бүлэгтэй харьцуулахад доогуур байна.

4. Иймд цаашид эрсдэлт бүлгийн хүн ам тэр дундаа ЭБҮ, ЭБЭ болон залуучуудын дунд ХДХВ-ийн халдвараас сэргийлэх, БЗДХ-ийг чиглэлээр хэрэгжүүлж буй хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээг өргөжүүлж эрчимжүүлэх шаардлагатай байна.

## Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дундаах ХДХВ, тэмбүү, хепатит В, С вирусийн халдвартын тархалт, зарим эрсдэлт хүчин зүйлийн судалгааны дүн

Г.Эрдэнэтуюя<sup>1</sup>, Д.Наранзуу<sup>1</sup>, Б.Шогтбаатарт<sup>2</sup>, Ч.Эрдэнэчимэг<sup>1</sup>, Д.Даваалхам<sup>3</sup>

<sup>1</sup> Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

<sup>2</sup> Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэтэй тэмцэх төсөл,

<sup>3</sup> Эрүүл Мэнд Шинжлэх Ухааны Их Сургууль

Манай улсад ХДХВ/ДОХ-ын анхны тохиолдол 1992 онд бүртгэгдсэнээс хойш 2010 оны 3 сарын байдлаар 64 тохиолдол бүртгэгдэж, 9 хүн нас барсан байна. ХДХВ/ДОХ-тай бүртгэгдсэн хүмүүсийн 75.0% эрэгтэйчүүд байна. Үүний 84.0% нь эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүд байна.

**Зорилго:** Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд ХДХВ, тэмбүү, хепатитын В, С вирусийн халдвартын тархалт, зарим эрсдэлт хүчин зүйлийг тогтоох зорилгоор дараах зорилтуудыг шийдвэрлэв:

1. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд ХДХВ, тэмбүү, хепатитын В, С вирусийн халдвартыг ийлдэс судлалын аргаар тогтоох

2. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд хепатитын В, С вирусийн халдвартын тархалтын зарим эрсдэлт хүчин зүйлийг судлах

**Материал, арга зүй:** Улаанбаатар хотод амьдарч буй эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн дунд ХДХВ, тэмбүү, хепатитын В, С вирусийн халдвартын тархалт, зарим эрсдэлт хүчин зүйлийг тогтоох судалгааг нэг агшингийн загвараар хийж

гүйцэтгэв. Шинжилгээг БНСҮ-ын Standart Diagnostics, INC-д үйлдвэрлэсэн өвөрмөц болон мэдрэг чанар 99%-тай SD Bioline хурдавчилсан оношлуураар хийж гүйцэтгэв. Судалгааг 2010 оны 4 дүгээр сараас 8 дугаар сарын 1-ийг хүртэл 4 сарын хугацаанд Улаанбаатар хотын 9 дүүрэгт амьдарч буй 16-50 насны эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 180 эрчүүдийг хамруулан хийв.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 181 эрчүүдийн 14%(25)-д хепатитын В вирусийн гадаргуугийн HBsAg зэрэг, 15%(27)-HCV зэрэг, 13,3% (24) ХДХВ-ийн халдвар, 14%(25)-д нь тэмбүүгийн халдвар тус тус илэрсэн. ХДХВ-ийн халдвар илэрсэн эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 3% нь шинэ халдвар, 10% нь өмнө нь ХДХВ-ийн халдвар оношлогдож одоо хяналтанд байгаа хүмүүс хамрагдсан. Энэхүү судалгааны ажлын явцад ХДХВ-ийн халдвaryн 6 шинэ тохиолдлыг эрт илрүүлэн хяналтанд авсан нь хувь хүнд төдийгүй нийгэм, хамт олны эрүүл мэндэд ихээхэн ач холбогдолтой, цаг үеэ олсон судалгаа болохыг харуулж байна. ХДХВ-ийн халдвар илэрсэн ЭБЭ нь 20-45 насны зацуучууд байгаа бөгөөд шинээр ХДХВ-ийн халдвартай болох нь оношлогдсон 6 хүн нь 20-42 насны эрчүүд байна. Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 181 эрчүүдийн 14%(25)-д хепатитын В вирусийн гадаргуугийн HBsAg зэрэг, 15%(27)-HCV зэрэг, 8%-хепатитын В, С вирусийн хавсарсан халдвар илэрсэн. Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог 181 эрчүүдийн 14%(25)-д тэмбүүгийн халдвар илэрсэн байна. Үүний 4%(8) шинэ, 10%(17) нь өмнө нь тэмбүүгийн халдвар авсан нь оношлогдож хяналтанд байгаа хүмүүс хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан эрчүүдийн 8%-д ХДХВ, тэмбүүгийн хавсарсан халдвар оношлогдсон байна.

#### Дүгнэлт

1. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 13,3%-д ХДХВ-ийн халдвар илэрч үүний 3% нь шинэ халдвар байгаа нь ЭБЭ олон нийтийн дунд ХДХВ-ийн халдвар үргэлжлэн тархсаар байгааг харуулж байна.

2. Эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 14%-д хепатитын В вирусийн гадаргуугийн HBsAg зэрэг, 15%-д HCV зэрэг, 8%-д нь хепатитын В, С вирусийн хавсарсан халдвар илэрсэн нь хепатитын вирусийн халдварлалт өндөр байгааг нотолж байна.

3. Судалгаанд хамрагдсан эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүдийн 14%-д тэмбүүгийн халдвар илэрч, 8%-д ХДХВ, тэмбүүгийн хавсарсан халдвар оношлогдсон нь ЭБЭ олон нийтийн дунд БЗДХ өндөр байгааг харуулах үзүүлэлт юм.

## Монгол хүүхдүүдийн дундах Кавасакийн өвчний эргэмж судалгаа

Д.Байгалмаа<sup>1</sup>, Б.Отгончимэг<sup>2</sup>, Д.Даваалхам<sup>3</sup>

<sup>1</sup> Халдварт Өвчин Судаллын Үндэсний Төв,

<sup>2</sup> Эх Нялхасын Эрдэм Шинжилгээний Төв

<sup>3</sup> Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуул

Кавасакийн өвчнийг (КӨ) анх 1967 онд Японы хүүхдийн эмч, эрдэмтэн Томисаку Кавасаки илрүүлсэн бөгөөд эдүгээ дэлхий даяар уг өвчний шинэ тохиолдлууд бүртгэгдэх болжээ. КӨ нь зүрхний титэм судсыг гэмтээх аюултай ба өндөр хөгжилтэй орнуудын хүүхдийн зүрх судасны олдмол гажгийн тэргүүлэх шалтгаан болоод байна.

КӨ нь өндөр халуурах, уруул ба амны хөндийн салст улайх, мөчдөл өөрчлөлт гарах, арьсан дээгүүр янз бүрийн хэлбэр бүхий тууралт гарах, тунгалагийн булчирхай томрох шинжилгэээр илэрдэг. Эрт үед нь оношлож, тохирсон эмчилгээг хийгээгүйн улмаас өвчлөгсдийн 20-25% нь зүрхний титэм судасны цүлхэн, өргөсөлөөр хүндэрч, улмаар зүрхний шигдээс, цус тасалдал өвчнөөр нас бараад хүрдэг.

Нийт өвчтэй хүмүүсийн 85% нь 5 хүртэлх насны хүүхдүүд байдаг ба өвөл, хаврын цагт өвчлөл оргил үедээ хүрдэг ажээ. КӨ-ний тохиолдол Америк, Европ, Ази тивийн 60 гаруй оронд бүртгэгдэж, 10 гаруй оронд энэ өвчний дэгдэлт гарсан. Өнөө үед дэлхийд жил бүр 100,000 хүн амд 3,4-186,0 шинэ тохиолдол бүртгэгдэж байна.

Манай хөрш зэргэлдээ улсууд болох Оросын Холбооны Улсад 100,000 хүн амд 18,2, Хятад улсад 30,2 КӨ-ний шинэ тохиолдол гарч байна.

Гэтэл манай улсын хувьд өнөөг хүртэл КӨ-ний талаар мэдээлэл байхгүй, энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй бөгөөд КӨ-ний талаарх эмч нарын мэдлэг хангалтгүй байгаагаас буруу оношлох, тохирсон эмчилгээ хийгдэхгүй байх, улмаар өвчин хүндэрх, нас баралтанд хүргэх зэрэг асуудлууд тулгамдаж байна.

**Зорилго:** Улсын хэмжээнд Монгол хүүхдийн дундах КӨ-ний тохиолдлыг илрүүлэн судлах.

**Материал, арга зүй:** Бид судалгаандаа Монгол улсын 21 аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн Эрүүл Мэндийн Нэгдэл, ЭНЭШТ-ийн зүрх судас, хүүхдийн тасгүуд, ХӨСҮТ-ийн амьсталын замын халдвaryн тасгүудад 1996-2008 оны хооронд хэвтэж эмчлэгдсэн 0-16 настай 241705 хүүхдүүдийн өвчний түүхэнд эргэмж судалгааг хийж, Японы Кавасакийн Өвчин Судаллын Төвөөс боловсруулсан Кавасакийн өвчний оношлогооны удирдамжийг ашиглан КӨ-ний тохиолдлыг илрүүллээ.